**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Анан ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/288/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас:70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер : Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayrkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 315558 Цахим хаяг: gantuguss@audit.gov.mn<br><br>Си Эс Ай аудит ХХК-ийн захирал: М.Сэвжидмаа<br>Утас: 19001981. Цахим хаяг: csi_sevjee@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 551

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АНАН ӨЭМТ-ИЙН ДАРГА Т.НАРАНТУЯА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Анан ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 918.4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Анан ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 26 байхаар баталж, 24 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026 өмнө дүгнэлт\Дүгнэлт 2026.docx
1426050421

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Анан ӨЭМТ нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартаар бүртгэж, санхүүгийн тайлангаа аж ахуйн нэгжид мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгын маягтад хөрвүүлж гаргасан байна.

**Бусад хэсэг**

Тус ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 95.5 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

# ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | * |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | * | * |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,397,940.99 | 10,518,374.72 |
| 1.1.2 | Дансны авлага | 55,837,012.45 | 12,257,840.20 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 2,372,591.05 | - |
| 1.1.6 | Бараа материал | 41,259,659.66 | 34,841,941.64 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **100,867,204.15** | **57,618,156.56** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | * | * |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 220,679,793.45 | 179,927,935.41 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **220,679,793.45** | **179,927,935.41** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **321,546,997.60** | **237,546,091.97** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | | 2,756,842.10 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 5,360,140.00 | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **5,360,140.00** | **2,756,842.10** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **5,360,140.00** | **2,756,842.10** |
| **2.3** | **Эздийн өмч** | **-** | |
| **2.3.1** | **Өмч:** | **59,330,836.60** | **59,330,836.60** |
| 2.3.1.1 | Төрийн | | |
| 2.3.1.2 | Хувийн | | |
| 2.3.4 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| 2.3.7 | Хуримтлагдсан ашиг | 256,856,021.00 | 175,458,413.27 |
| **2.3.9** | **Эздийн өмчийн дүн** | **316,186,857.60** | **234,789,249.87** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **321,546,997.60** | **237,637,296.40** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **933,781,268.87** | **918,425,008.00** |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | |
| **3** | **Нийт ашиг ( алдагдал)** | **933,781,268.87** | **918,425,008.00** |
| 5 | Хүүний орлого | | |
| 8 | Бусад орлого | 80,581,456.46 | 12,761,047.72 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 992,677,047.56 | 1,012,435,583.45 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (21,054.00) | (148,080.00) |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **21,664,623.77** | **(81,397,607.73)** |
| 19 | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **21,664,623.77** | **(81,397,607.73)** |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **21,664,623.77** | **(81,397,607.73)** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | **-** | |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | |
| **24** | **Нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | **21,664,623.77** | **(81,397,607.73)** |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31** | **59,330,836.60** | | | **9,279,807.40** | | | **227,672,535.83** | **296,283,179.83** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | 21,664,623.77 |
| **Залруулсан үлдэгдэл** | **59,330,836.60** | | | **9,279,807.40** | | | **225,890,535.83** | **294,501,179.83** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | 21,664,623.77 | 21,664,623.77 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | (9,279,807.40) | | | 9,300,861.40 | 21,054.00 |
| Зарласан ногдол ашиг | | | | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | |
| **2024 оны 12-р сарын 31** | **59,330,836.60** | | | | | | **256,856,021.00** | **316,186,857.60** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **59,330,836.60** | | | | | | **256,856,021.00** | **316,186,857.60** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | | | **(81,397,607.73)** | **(81,397,607.73)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | |
| **2025 оны 12-р сарын 31** | **59,330,836.60** | | | | | | **175,458,413.27** | **234,789,249.87** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1.** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **1.1.0** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **920,797,427.42** | **971,164,876.09** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 877,944,257.02 | 165,455,000.00 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 1,338,000.00 | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | 111,709.00 |
| 1.1.5 | Татаас санхүүжилтийн орлого | | 741,100,998.40 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 41,515,170.40 | 64,497,168.69 |
| **1.2.** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **919,942,346.92** | **954,994,443.08** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 598,643,745.00 | 720,481,914.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 138,598,008.40 | 84,720,294.45 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 65,151,312.55 | 55,887,951 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 11,746,770.60 | 16,870,242.00 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 7,833,600.00 | 6,641,750.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 47,979,459.97 | 10,445,858.30 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 49,989,450.40 | 59,956,433.33 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **855,080.50** | **16,150,433.01** |
| **2.** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **5,000,000.00** | |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 5,000,000.00 | |
| **2.2.** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **8,380,000.00** | **7,050,000.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 3,380,000.00 | 7,050,000.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 5,000,000.00 | |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(3,380,000.00)** | **(7,050,000.00)** |
| 3. | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | | |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | | |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | | |
| 4. | Валютын ханшийн зөрүү | | |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (2,524,919.50) | 9,120,433.01 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **3,922,860.49** | **1,397,940.99** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,397,940.99** | **10,518,374.00** |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой холбоотой нийт 9,320.2 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд:

Аудитаар нийт 2,110.1 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 2,110.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2,110.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал илүү байгуулсан байна; | 1 | 547.3 | | | 1 | 547.3 | **1** | 547.3 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, зарлагыг дутуу тайлагнасан | 1 | 8,772.9 | 1 | 8,772.9 | | | 1 | 8,772.9 | | | | |
| **Дүн** | **2** | **9,320.2** | **1** | **8,772.9** | **1** | **547.3** | **2** | **9,320.2** | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нэр бүхий ажилтнуудад олгосон цалин, хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй цалинг илүү олгосон байна. | 1 | 1,236.8 | 1 | 1,236.8 | | | | | | | | |
| Тус ӨЭМТ нь ээлжийн амралтын олговрыг нэр бүхий ажилтнуудад илүү олгосон байна. | 1 | 873.3 | 1 | 873.3 | | | | | | | | |
| "Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2022 онд УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан нь мөрдвөл зохих ЖДААН-ын СТОУС-тай зөрчилдөж байна. Түүнчлэн, уг баримт бичгийг хууль тогтоомж, стандартын шинэчлэлд уялдуулан засварлаагүй, нөхөрлөлийн үйл ажиллагааны онцлогийг тусгаагүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **3** | **2,110.1** | **2** | **2,110.1** | | | **1** | **-** | | | | |